

Залилан мэхлэх (цахим) гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлс

Амарсайханы Манлай

Доктор (Ph.D), төвийн дарга, amarsaikhanmanlai@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Цагдаагийн ерөнхий газрын

Стратеги, бодлого, инновац, хөгжлийн алба

Хураангуй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь залилан мэхлэх (цахим) гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлахыг зорьсон юм. Орчин үеийн цахим технологийн хурдацтай дэвшил нь бидний амьдралыг илүү хялбарчилж, тав тухтай болгож байгаа хэдий ч гэмт хэрэг үйлдэх шинэ боломжуудыг нэгэн зэрэг нээж өгсөөр байна. Үүний тод жишээ нь цахим залилан мэхлэх гэмт хэргийн хэлбэр, цар хүрээ өдрөөс өдөрт нэмэгдэж, нийгэмд ноцтой аюул учруулж буй явдал юм.

Өгүүлэлд цахим залилан мэхлэх гэмт хэргийн олон улсын болон Монгол Улсын хэмжээнд үүсээд буй өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэхүү гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн шинжилсэн. Судалгааны үр дүнд үндэслэн цахим залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх практик зөвлөмжүүдийг боловсруулж, цаашидын судалгааны чиглэлийг тодорхойлсон болно. Энэхүү өгүүлэл нь цахим гэмт хэргийн эсрэг тэмцэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Түлхүүр үг: Кибер аюулгүй байдал, гэмт хэргийн шалтгаан, мэдээллийн хамгаалалт, урьдчилан сэргийлэлт, нийгмийн эмзэг байдал

Оршил

Залилах гэмт хэрэг энэ оны эхний долоон сард өмнөх оноос 57.1 хувиар өссөн нь нийт гэмт хэрэг 24.4 хувиар нэмэгдэхэд шууд нөлөөлжээ. Улсын хэмжээнд бүртгэгдэж буй гэмт хэргийн бүтцэд залилах хэрэг 25.7 хувийг эзэлж, түүний үйлдлийн арга цахим хэлбэрт шилжсэн нь урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх санал бүхий судалгаа хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна. Иймд Паретогийн оновчлолын зарчим буюу нийт гэмт хэргийн өсөлтийн үндсэн шалтгааныг гол жин дарж буй хэргийн шалтгаан, нөхцөлтэй холбон судлах, улмаар цагдаагийн байгууллагын алба, нэгжүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай зөвлөмжийг боловсруулах зорилгоор доорх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг гэмт хэргийн статистикт шинжилгээ хийх, түүний чиг хандлагад үнэлгээ өгөх, харьцуулсан аналитик судалгаа хийх арга зүйн үндсэн дээр


гүйцэтгэсэн болно. Судалгааны ажлыг Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны Судалгаа, дүн шинжилгээний төвийн алба хаагчид багаар хийсэн ба судалгааны явцад статистик өгөгдлийг боловсруулж, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ, залилах гэмт хэргийн хандлага болон нөлөөлөгч хүчин зүйлсийн уялдаа холбоог тогтоох зорилгоор аналитик болон кейс судалгааны аргачлалыг түлхүү хэрэглэсэн.

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал

1.1. Гэмт хэргийн статистик

Цахим залилангийн гэмт хэргийн статистик мэдээнээс энэ төрлийн гэмт хэргийн шалтгааныг олж тогтоох зорилгоор зарим онцлог тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд үйлдлийн арга, давтамж нь анхаарал татаж байна. Цахим сүлжээ ашиглан далд хэлбэрээр удаа дараа хохирогчдыг олзлон хуурч, мэхлэх аргаар залилсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс хэд дахин өссөнийг үйлдлийн арга тус бүрээр нь харуулбал:

График 1. Үйлдлийн арга



Энэ төрлийн гэмт хэргийн тархац нийслэлийн Баянзүрх, Баянгол дүүрэг, орон нутагт Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймагт нягтрал ихтэй бүртгэгдсэн ба хохирогч 75.6, холбогдогч 81.6 хувиар огцом өссөн. Иргэд цахим аюулгүй байдлын талаар хангалттай мэдлэггүй байгаагаас фишинг, хуурамч мэдээлэлд өртөх, хувийн мэдээллээ алдах тохиолдол нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн өсөлтөд мөн нөлөөлж байна.

Цахим залилангийн төлөв хандлагыг систем динамикийн аргачлалаар тооцоход интернэт хэрэглэгчдийн тооноос хамаарч улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2030 он хүртэл 40.0 хувийн тогтмол өсөлттэй байх төлөвтэй байна (ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба, 2023). Жишээ нь: өнгөрсөн

оны эхний долоон сард улсын хэмжээнд телеграм ашигласан залилангийн тоо нэг байсан бол энэ онд 685 болж огцом өссөн. Энэ мэтээр цахим аппликейшны нууцлал өндөр байдгаас ул мөр илрүүлж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг тул гэмт хэргийн шинжтэй сувгуудыг хаах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал байна.

Судалгааны дүн болон олон улсын туршлагаас харахад цахим гэмт хэргийн эсрэг үр дүнтэй арга зам нь контентыг хязгаарлахаас гадна, өгөгдөлд суурилсан автомат илрүүлэлт, хиймэл оюунд тулгуурласан хяналтын системийг ашиглах замаар хууль бус үйлдлийг эхэн үед нь илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршиж байна.

1.2. Кейс судалгаа

Судалгаагаар цахим залилангийн үйлдлийн аргын 33.3 хувь нь онлайн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах нэрээр, 23.1 хувь нь хохирогчийн танил, хувийн мэдээллийг ашиглаж, 21.4 хувь нь эх сурвалж тодорхойгүй цахим хаягт хандалт хийснээр үйлдэгджээ (ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба, 2023). Шүүхээр энэ оны наймдугаар сард шийдвэрлэсэн гурван хэргээс жишээ татахад 100 гаруй хүн өртөж хохирчээ. Үүнд: шүүгдэгч М, П нар бүлэглэн цахим орчинд фейсбүүк сүлжээ ашиглан “гэр шатсан”, “хүүхэд өвдсөн”, “хагалгаанд орох шаардлагатай” гэх хуурамч мэдээлэл бүхий зарыг байршуулж, бусдыг төөрөгдөлд оруулан 25 удаагийн үйлдлээр хандив залилсан (Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, 2025). Шүүгдэгч Б нь фейсбүүк сүлжээ ашиглан “заал өгч байна” гэсэн хуурамч зар байршуулан зарын дагуу холбогдсон иргэдээс түрээсийн төлбөрийг урьдчилан авч, удаа дараагийн үйлдлээр 98 хүнд хохирол учруулсан (Улсын дээд шүүхийн тогтоол, 2025). Шүүгдэгч Х нь хохирогч руу фейсбүүк чатаар хандаж, дархан цаазат газар нутагт газар ашиглах эрхийн гэрчилгээ гаргуулж өгнө, тушаал гарсан хэмээн хуурч, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хуурамч тушаалын зураг цахимаар явуулан мөнгө шилжүүлэн авчээ (Улсын дээд шүүхийн тогтоол, 2025).

Мөн цагдаагийн байгууллагын хоногийн мэдээнд авагдаж буй залилах гэмт хэргийн тоон үзүүлэлтэд дунджаар эхнээсээ хоёрт жагсаж, эдгээр бүртгэгдсэн хэргийн 70 хувь нь бүртгэгдэх үедээ эзэн, холбогдогч тодорхойгүй болон цахим сүлжээгээр үйлдэгдсэн байна (Цагдаагийн ерөнхий газар, 2025). Эдгээрээс түүврийн аргаар судалгаа хийж, энэ оны наймдугаар сарын 26-ны өдөр бүртгэгдсэн залилах төрлийн есөн хэргийг жишээ татаж үзвэл дөрөв нь телеграмм, нэг нь Тик токоор залилуулсан тохиолдол байна. Тухайлбал: иргэн О нь телеграмаар даалгавар биелүүлж нэр бүхий банкны зургаан данс руу 35.7 сая төгрөг шилжүүлж залилуулсан хэргийг Архангай аймгийн цагдаагийн газарт, иргэн “П” телеграмаар даалгавар биелүүлж, нийт долоон удаагийн гүйлгээгээр 33.8 сая төгрөгийг залилуулсан хэргийг Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст, иргэн “Г” нь телеграмаар мөнгө өсгөнө гэх зарын дагуу гурван удаагийн гүйлгээгээр 6.3

сая төгрөгийг залилуулсан хэргийг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст, иргэн “Т” нь Тик токоор даалгавар биелүүлж 37.0 сая төгрөгийг шилжүүлж залилуулсан мэдээллийг Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус шалгаж байна.

Хоёр. Мөрдөн шалгах ажиллагаа

Цагдаагийн байгууллагаас энэ оны эхний долоон сарын байдлаар “Залилах” төрлийн нийт 17807 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 41.7 хувь буюу 7423 хэргийг шалгасны 3786 буюу 51.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж, 12 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож, 2854 буюу 38.5 хувийг үйлдэл, холбогдлоор нэгтгэн, 179 буюу 2.3 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, 592 буюу 8.0 хувийг шүүхэд шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд 159.7 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 31.8 тэрбум төгрөг буюу 19.9 хувийг нөхөн төлүүлж, 20.6 сая төгрөгийг битүүмжилсэн байна.

Залилах гэмт хэргийн дийлэнх нь цахим орчинд, техник технологи болон олон улсын сүлжээг ашиглан шинэ хэлбэрээр үйлдэгдэж байгаа нь гэмт этгээдийг олж тогтоох, мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иргэдийн цахим хэрэглээ нэмэгдэхийн хэрээр аюулгүй байдал, мэдээллийг нууцлалыг алдсанаар гэмт хэргийн хохирогч болох, энэ талаар цагдаагийн байгууллагад мэдээлэхдээ ихэвчлэн хугацаа алддаг нь нотлох баримт устах эрсдэлийг бий болгож байгааг Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн мэдээлэлд онцолсон.

Мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын ачаалал, техник технологийн хангамж, мэргэшсэн байдал хангалтгүй, цахим ул мөр тогтоох тусгай мэдлэг бүхий ажилтан дутмаг байгаа нь шуурхай, бүрэн нотолгоо цуглуулах боломжийг хязгаарлаж байна. Ялангуяа мөрдөгчийн шаардсан лавлагаа, мэдээлэл, баримт бичгийг банк, холбооны оператор зэрэг байгууллагаас хугацаанд нь ирүүлдэггүйгээс хэрэг бүртгэл удааширч, нэмэлт ачаалал бий болж байна.

Эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уялдаа холбоо сул, илт гэмт хэргийн шинжгүй маргаантай асуудлыг цагдаагийн байгууллагад гаргаснаас мөрдөгчдийн ачаалал нэмэгдэж байгаа бол прокурор, шүүхийн шатанд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хангалттай авч хэрэгжүүлдэггүй, нотолгоо бүрэн цуглуулаагүй зэрэг нь тэднийг оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг бүрдүүлж байна.

Залилах гэмт хэрэгт холбогдож буй этгээдүүд гадаадын IP хаяг, сервертэй платформ, аппликэйшн ашиглаж байгаа нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулж байна. Ялангуяа фейсбүүк, телеграм зэрэг олон улсын платформын хэрэглэгчийн мэдээлэлд хандах боломж хязгаарлагдмал, жишээлбэл “Meta” компани хөнгөн гэмт хэргийн үед хэрэглэгчийн мэдээлэл гаргаж өгөх боломжгүй гэдэг нь мөрдөн шалгалтыг удаашруулдаг.

Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон мөнгөө олон улсын болон цахим мөрийтэй тоглоомын (1xBET, MelBET, цахим покер зэрэг) данс руу шилжүүлэх, гадаад улсын банкны дансанд байршуулж дамжуулах, эсвэл виртуал хөрөнгө болгон хувиргах нь мөнгөний урсгалыг мөрдөх, хохирлыг нөхөн төлүүлэхэд хүндрэл үүсгэж буй практик жишээ болохыг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчид онцолж байна. Мөн гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах эрх зүйн орчин дутмаг, яаралтай мэдээлэл солилцох механизм бүрдээгүйгээс мөрдөн шалгах ажиллагаа удаашрахад хүрч байгаа болно.

Гурав. Олон улсын туршлага

Олон улсын дата аналитикийн байгууллагаас гаргасан статистик мэдээгээр дэлхий даяар цахим залилангийн гэмт хэрэг 10.0 их наяд орчим ам.долларын хохирол учруулж байна. Коронавирусын цар тахлын улмаас 2020 оноос эхлэн улс орнууд хөл хорио тогтоосноор цахим худалдан авагчдын тоо жил тутам 20 хувиар өсөж байгаагаас цахим залилан хурдацтай өссөн гэж шинжээчид үзжээ (Р.Хохайсел., Г.В.Капеллвин., Д.К.Сарма., М.Юнгер, 2023) (С.Кресчи Али Ф.Аль-Кахтани, 2022).

Судлаачдын хийсэн дүгнэлтээр цахим сүлжээний төрөл, хэрэглэгчдийн хүрээ тэлэх тусам залилах гэмт хэргийн хохирогчдын тоо үржүүлэхийн хүрд адил нэмэгдэх ба ирээдүйд бүртгэгдэх гэмт хэргийн дийлэнх хувийг эзлэх болно. Тухайлбал: АНУ-ын Холбооны мөрдөх товчооны 2020 онд хийсэн судалгаагаар олон улсад хууль бус онлайн худалдаа эрхэлж буй “Silk Road”, “Alpha Bay”, “Hush Hush” зэрэг гурван мянга орчим цахим хуудас бүртгэгджээ.

Зарим улс орны нөхцөл байдлыг жишээ татаж үзвэл энэ оны эхний хагаст Орост бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 38.2, Японд 15, Европын холбооны гишүүн орнуудад 25, үүнээс Швейцарт 67, Хятадад 36 хувь нь тус тус цахим залилан байна. Өөрөөр хэлбэл: Олон улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн дунджаар 1/3-ийг эзэлж байна.

Улс орнуудад цахим залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй хамгийн шалгарсан арга нь хууль сахиулах байгууллагын дэргэд 24/7 ажиллагаатай нэгж (Scam Response Unit, Scam Intelligence Fusion Hub) байгуулж, бүх төрлийн цахим залилангийн гомдлыг төвлөрүүлэн бүртгэх, дүн шинжилгээ хийх, банкууд руу хөрөнгийг царцаах мэдэгдэл илгээх арга хэмжээ юм. Иргэд залилангийн гүйлгээг 30 минутаас богино хугацаанд мэдээлбэл царцаах магадлал өндөр ба дараачийн хүмүүс хохирохоос сэргийлдэг тул уг арга хэмжээг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамгийн үр дүнтэй гэж үздэг.

Мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр мөн ялгаагүй хөрөнгийн урсгалыг шуурхай илрүүлж, нэн даруй царцаах (cooling-off period), улмаар мөнгөн гүйлгээ хийх замыг хаах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээ авч байна. Түүнчлэн сэжигтэй гүйлгээ, дансны мэдээллийг хиймэл оюун ухаанд суурилсан мэдээллийн системээр

шалгах нь богино хугацаанд цахим залиланг таслан зогсоох хэрэгсэл болж байна. Тухайлбал: худалдан авалт, бусад хэлбэрээр шилжүүлэг хийхийн өмнө тухайн дансны нэр, дугаарыг цагдаагийн байгууллагаас олон нийтэд зориулан бэлтгэсэн хайлтын системээр иргэд өөрсдөө шалгах боломжоор хангадаг. Хэрвээ тухайн шалгасан данс сэжигтэй, хууль бус гүйлгээ хийсэн хар дансанд орсон бол тухай бүр цахим хуудаст хандсан иргэдэд анхааруулга өгдөг байна.

Хууль сахиулах албадаас хэрэгжүүлж буй өөр нэг арга хэрэгсэл нь Мобайл операторуудтай хамтран сэжигтэй дугаар таслах гэдэг нь залилангийн гэмт хэрэгт ашиглагдаж буй SIM карт болон IP суурилсан дуудлагын сувгуудыг цагдаагийн хүсэлтээр шуурхай хаах ажиллагааг хэлнэ. Ингэснээр хохирлыг богино хугацаанд бууруулж, залилангийн тархалтыг таслах чухал үр дүнд хүрдэг. Өөрөөр хэлбэл: Залилах гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга нь таслан зогсоох ба үүгээрээ дараагийн хохирогчийг хамгаалдаг. Харин тухайн гэмт хэрэг бүрийг мөрдөн шалгах, эсхүл урьдчилан сэргийлэх санамж анхааруулга өгөх нь таслан зогсоох арга хэмжээтэй харьцуулахад үр дүн, нөлөөлөл багатай аргууд юм.

Залилах гэмт хэрэгтэй тэмцэж буй цагдаагийн үйл ажиллагааны үр дүнг ч мөн адил гомдол бүртгэхээс эхлэн хөрөнгө царцаах хүртэлх дундаж хугацаагаар хэмжиж тооцдог байна. Тухайлбал: Европын холбооны “Rand” үнэлгээний байгууллагаас хийсэн судалгаагаар цагдаагийн байгууллагын ажлыг хэмжих үндсэн дөрвөн үзүүлэлтийн 2 дугаарт гэмт хэрэг (залилах)-ийг түргэн таслан зогсоох арга хэмжээ авснаар нь хэмжиж байна (Ранд судалгааны агентлаг Э.Цюрчер Л.Екельшот А.Волке Л.Стрэнг, 2023).

Дүгнэлт

Цахим залилангийн гэмт хэрэг нийслэл болон зарим аймагт олноор бүртгэгдэж, үйлдлийн арга улам төрөлжин, хохирогч, холбогдогчдын тоо огцом өсөж байгаа нь иргэдийн цахим аюулгүй байдлын мэдлэг дутмаг, нууцлал өндөртэй сүлжээ ашиглах нөхцөлтэй холбон дүгнэж болно.

Судалгаагаар энэ төрлийн гэмт хэрэг 2030 он хүртэл 40 орчим хувийн тогтвортой өсөлттэй байх төлөвтэй тул зөвхөн контент хязгаарлах бус өгөгдөлд суурилсан автомат илрүүлэлт, хиймэл оюун ухаанд тулгуурласан хяналт болон олон нийтийн цахим боловсролыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байгаа юм.

Залилах төрлийн 17807 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг энэ оны эхний долоон сарын байдлаар явуулж, нийт 159.7 тэрбум төгрөгийн хохирол учирснаас зөвхөн 19.9 хувийг нөхөн төлүүлсэн. Энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн цахим орчинд олон улсын сүлжээ, гадаадын сервер, платформ ашиглан шинэ хэлбэрээр үйлдэгдэж байгаа нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл үүсгэж, нотолгоо цуглуулах, мөнгөний урсгалыг мөрдөх, хохирлыг нөхөн төлүүлэхэд саад болж байна. Үүний зэрэгцээ хууль сахиулах байгууллагын техник, боловсон хүчний

хангалт, мэргэшсэн байдал, байгууллагуудын уялдаа холбоо дутмаг байгаа нь мөрдөн шалгалтыг удаашруулж, гэмт этгээдүүд оргон зайлж, дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдүүлж байгааг харуулж байна.

Дэлхий дахинд цахим залилангийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн гуравны нэгийг эзэлж, жил бүр огцом өсөхийн хэрээр улс орнууд хөрөнгийг шуурхай царцаах, хиймэл оюунд суурилсан илрүүлэлт, сэжигтэй дугаарыг таслан зогсоох зэрэг арга хэмжээг голчлон хэрэгжүүлж байгаа нь урьдчилан сэргийлэхээс илүү үр дүнтэй болохыг онцолсон байна.

Эх сурвалжийн жагсаалт

Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. (2025 оны 8 14). Шүүхийн шийтгэх тогтоол №2025/ШЦТ/145. Улаанбаатар.

Р.Хохайсел Г.В.Капеллвин Д.К.Сарма М.Юнгер. (2023). *COVID-19 тахлын үеийн фишингийн хөгжил*.

Ранд судалгааны агентлаг Э.Цюрчер Л.Екельшот А.Волке Л.Стрэнг. (2023). *Цагдаагийн гүйцэтгэлийн хэмжилтийн олон улсын хандлага*. Европын холбоо.

С.Кресчи Али Ф.Аль-Кахтани. (2022). *COVID-19 залилан: Дэлхий дахины хохирлыг илрүүлэх судалгаа*.

Улсын дээд шүүхийн тогтоол. (2025 оны 05 28). Улсын дээд шүүхийн тогтоол № 2025/ХШТ/73. Улаанбаатар.

Цагдаагийн ерөнхий газар. (2025). *Хоногийн нөхцөл байдлын мэдээ*. Улаанбаатар.

ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба. (2023). *Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ*. Улаанбаатар.

Causes, Conditions, and Influences Cyber Fraud

Manlai Amarsaikhan

Doctor (Ph.D), Head of Center, amarsaikhanmanlai@gmail.com
Strategy, Policy, Innovation and Development Department of
National Police Agency, Ulaanbaatar, Mongolia

Abstract

This research article aims to comprehensively study the causes, conditions, and influencing factors of cyber fraud crimes. The rapid progress of modern electronic technology makes our lives easier and more comfortable, at the same time it has opened up new opportunities for committing crime. A clear example of this, is the increasing forms and scale of cyber fraud, posing serious threat to societal wellbeing.

The article presents the current situation and statistical information on cyber fraud both on domestic and international levels. It also provides an in-depth analysis of the main factors influencing the commission of such crimes. Based on the results of the study, I propose practical recommendations for combating and preventing cyber fraud crimes, and identified directions for further investigation. It is hoped that this article will aid meaningfully to efforts aimed at countering cybercrimes, I believe that this article will contribute to the fight against cybercrime.

Keywords: Cybersecurity, Causes of Crime, Information Security, Prevention, Social Vulnerability.

Received: September 8, 2025 | Accepted: September 15, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.